

*Эзлэжээ - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 8032 дугаар дамжааны суралцагч,*

*цагдаагийн хошууч
Б. Одбаатар - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын
багийн профессор, доктор (Ph.D)
цагдаагийн хурандаа*

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хураангуй: Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалт, сургалтын төрөл хэлбэрийг талаар судалж, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, сургалтын чанарыг сайжруулахад анхаарах асуудлыг тодорхойлохыг зорилго.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллагын хүний нөөц, сургалтын арга, хэлбэр

Нэг. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалтын зорилго, ач холбогдол

Аливаа байгууллага, түүний дотор төрийн захиргааны байгууллагын амжилттай ажиллах чухал нөхцлийн нэг нь хүн хүч буюу хүний нөөц байдаг. Хэрвээ хүмүүсийг зөв удирдаж, төлөвлөж, сургаж хөгжүүлж чадвал үр ашигтай хөдөлмөрлөхийн зэрэгцээ түүний бүтээлч чадамж нь үйл ажиллагаанд нь илэрч улмаар аливаа байгууллага, тэр дундаас цагдаагийн байгууллагын төрөл мэргэжлийн албад үндсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгодоо хүрнэ.

Цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаанд хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад албаны болон мэргэжлийн сургалт чухал байр суурь эзэлдэг билээ.

Цагдаагийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш цагдаагийн байгууллагад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж цэрэгжсэн хэлбэрээс хууль сахиулах мэргэшсэн байгууллага болгох үйл явц өрнөж байна.

Хэдийгээр эрх зүйн орчин шинэчлэгдэж байгаа боловч хуучин бүтэц тогтолцоонд ажиллаж дадсан алба хаагчдыг мэргэшүүлэн сургах, хөгжсөн орнуудын цагдаагийн туршлагыг судлуулж, хандлагыг нь өөрчлөх, удирдах албан тушаалтны манлайллыг бий болгох, энэ чиглэлээр сургалтын хэрэгцээ шаардлага байсаар байгаа юм.

Сургалт нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, мэргэжлийн бэлтгэл, ур чадвар, туршлага дутагдаж буй үед алба хаагчдыг тусгай бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу сургах үйл явц юм.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, давтан, мэргэшүүлж сургах сургалтын зорилго нь сургалтын төлөвлөлтөд байгууллага, алба хаагчийн эрэлт хэрэгцээг зохистой хослуулах, алба хаагчид сонголт хийх боломж, нөхцлийг бүрдүүлэх, мэргэжлийн сургалтын чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулах, ил тод, тэгш, шударга, сургалт үр дүнтэй байхад чиглэнэ.

Хүний нөөцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх нь бусад нөөцөд хөрөнгө оруулалт хийснээс илүү их үр ашигтай байдаг байна.¹

Сургалт зайлшгүй шаардлагатай дараах гурван нөхцөл байдаг. Үүнд:

1. Байгууллагад шинээр хүн ажилд ороход;
2. Ажилтаныг шинэ албан тушаалд томилох;
3. Ажил албан тушаалын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхийн тулд тухайн хүнд мэдлэг, туршлага дутагдаж байгааг хяналтаар тогтоосон үед сургалтыг явуулдаг байна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалт, хөгжлийн талаар цагдаагийн төв байгууллагаас дараах үндсэн чиглэлийг баримтална.*²

а/хүний нөөцийн сургалт, хөгжлийн урт, богино хугацааны стратеги. бодлого, чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх;

б/сургалтын стандарт, хөтөлбөрийн дагуу цагдаагийн болон харуул, хамгаалалтын анхан шатны мэргэжлийн болон олон нийт-цагдаагийн ажилтныг бэлтгэх сургалтыг зохион байгуулах;

в/цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн дээд /бакалавр/ боловсролтой, мэдлэг, ур чадвартай алба хаагчийг гадаад, дотоодын мэргэжлийн сургалтын байгууллагад захиалгаар бэлтгэх, сургалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

г/гадаад, дотоодын их, дээд сургуулийн бакалавр, магистр, доктор, адъюнктур, удирдах ажилтныг бэлтгэх сургалтад алба хаагчдыг суралцуулж, хөгжүүлэх;

д/гадаад, дотоодын тэтгэлэгт болон мэргэшүүлэх сургалтад алба хаагчийг суралцуулж, боловсролын зэргийг нь дээшлүүлж, хөгжүүлэх;

е/байгууллагын болон алба хаагчийн сургалтын хэрэгцээг харгалзан алба хаагчийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх давтан болон мэргэшүүлэх, ур чадварын сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулах;

Л.В Картошова. Управление человеческим ресурсами: учебник для программы.МВА Инфра Мостр 2005.С 181.

² Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.,2017 он

ж/алба хаагчийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх бүтээлч санаачлагыг дэмжиж, тэдний өөрийгөө хөгжүүлэх боломж, нөхцлийг бүрдүүлэх;

з/алба хаагчийн сургалт, хөгжлийн тогтолцоо, агуулга, арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга шинэчилж, боловсронгуй болгох.

Хоёр. Цагдаагийн байгууллагын сургалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, өнөөгийн нөхцөл байдал

Цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагааг ЦЕГ-ын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв болон бусад цагдаагийн төв байгууллагын харьяа албад, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн нэгжүүд хууль, журамд заасны дагуу хариуцан хэрэгжүүлдэг.

Ингэхдээ Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс нь албаны сургалтын бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үнэлгээ шинжилгээ хийх, нэгдсэн бүртгэл судалгаа хөтлөх болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв нь цагдаагийн албаны давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалт болон хууль тогтоомжид заасан бусад сургалтыг байгууллагын хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

Гадаад харилцааны хэлтэс нь байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд суурилан богино хугацааны гадаад сургалт, гадаадаас сургагч багш урьж оролцуулан явагдах аливаа сургалтуудыг хариуцан зохион байгуулж байна.

Бусад цагдаагийн байгууллага нь нэгжийн хэмжээнд алба хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах, бүртгэл судалгаа хөтлөх зэрэг үүргийг хэрэгжүүлж байна¹.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, хөгжүүлэх сургалтын тогтолцоо дараах төрлөөс бүрдэнэ*²:

а/цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалт;

б/цагдаа - мэргэжлийн дээд боловсролын сургалт/ бакалавр, магистр, доктор, адъюнктур/;

Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд сургалтын байгууллагын талаар дурьдаж өгсөн байна.

² Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.,2017 он

в/даван, мэргэшүүлэх, ур чадварын болон ажлын байран дахь үргэлжилсэн сургалт;

г/иргэд, олон нийтэд чиглэгдсэн бусад сургалт.

А. Цагдаагийн анхан шатны мэргэжлийн боловсролын сургалтыг цагдаагийн төв байгууллагын захиалгаар хууль сахиулагч бэлтгэх сургуулийн сургалтын тусгай зөвшөөрөл бүхий сургалтын нэгжид Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу өдрийн хэлбэрээр, 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар зохион байгуулах ба төгсөгчдөд мэргэжлийн үнэмлэх олгоно.

Б.Цагдаагийн мэргэжлийн бакалаврын зэргийн боловсролтой алба хаагчийг цагдаагийн төв байгууллагын захиалгаар цагдаагийн ажилтан, хууль сахиулагчийг бэлтгэх сургалтын тусгай зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын их. дээд сургууль, академид бэлтгэнэ.

Бакалаврын зэрэглэлийн өдрийн хэлбэрийн сургалтад цагдаагийн байгууллагад 1-ээс доошгүй жил ажилласан, эчнээ хэлбэрийн сургалтад цагдаагийн байгууллагад 3 ба түүнээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг харьяа байгууллагын саналыг харгалзан тус тус элсүүлэн суралцуулна.

Гадаад, дотоодын их, дээд сургууль, академийн цагдаагийн удирдах ажилтан бэлтгэх бакалавр, магистрын сургалтад цагдаагийн байгууллагад 6, түүнээс дээш жил ажилласан, удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн болон цагдаагийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчийг ажлын үр дүн, харьяа

В.Цагдаагийн алба хаагчийг гадаад, дотоодод давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтад хамруулах болон төрийн ба төрийн бус байгууллага, их. дээд сургуультай хамтарч сургалтыг зохион байгуулах ажлыг цагдаагийн төв байгууллагын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, нутаг дэвсгэр болон тодорхой нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага тус тус хариуцан танхимын, дадлагын, зайны сургалтын хэлбэрээр тус тус зохион байгуулна.

Давтан сургалт нь цагдаагийн алба хаагчийн нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн чадамжийг дээшлүүлж, дадал, чадварыг нь хөгжүүлэхэд чиглэгдэх ба ажлын 5-10 хоногийн хугацаагаар зохион байгуулагдана.

Мэргэшүүлэх сургалт нь алба хаагчдын тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын арга, тактикийн мэдлэг, ур чадварын түвшинг нь

дээшлүүлэх, цагдаагийн тодорхой албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшлийн чадамж олгох болон түвшинг нь дээшлүүлэх сургалт бөгөөд ажлын 4 цагаас 1 сар хүртэл хугацаанд зохион байгуулагдана.

Алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалтыг тодорхой орон зайнаас мэдээлэл, харилцааны хэрэгслүүдээр дамжуулан зайны сургалтын хэлбэрээр /утас, ном, сурах бичиг, гарын авлага, цахим харилцаа, видео г.м/ зохион байгуулж болно.

Г.Цагдаагийн төв байгууллага нь холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ дагуу харуул, хамгаалалтын болон олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх, иргэний зөвлөл, иргэдэд зориулсан сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх болон албаны сургалтын үйл ажиллагааг ерөнхийд нь гадаад болон дотоод сургалт гэж 2 ангилж болно.

Гадаад сургалт:

Цагдаагийн алба хаагчдыг бакалавр, магистр, докторын түвшний болон удирдлагын сургалтад Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Турк Улсад сурган бэлтгэж байна. ХНСХ-ийн судалгаанаас үзвэл 1998 оноос хойш БНТУ-д нийт 87 иргэнийг сонгон шалгаруулж сургасан бол 2001 оноос хойш ОХУ-ын нэр бүхий сургуулиудад нийт 215 иргэн, алба хаагчийг зохих түвшний сургалтуудад хамруулан бэлтгэжээ.

Түүнчлэн гадаад улс орнуудын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн сургалт, гадаад арга хэмжээнд 2016 онд давхардсан тоогоор 219 алба хаагчийг, 2017 онд 100, 2018.11 сард 169 алба хаагчийг тус тус хамруулжээ.

Мөн гадаад орны хамтын ажиллагаатай байгууллагатай хамтран сургагч багш урьж 2016 онд 5, 2017 оны 10 сарын байдлаар 5 богино хугацааны сургалтыг дотооддоо зохион байгуулж, цагдаагийн алба хаагчдыг хамруулсан байна.

Цагдаагийн төв байгууллага нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ дагуу харуул, хамгаалалтын болон олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх, иргэний зөвлөл, иргэдэд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явуулах үүргийг давхар хүлээсэн байна.

Дотоод сургалт:

1. Цагдаагийн мэргэжлийн сургалт

¹ Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ.,2017 он.

Цагдаагийн мэргэжлийн сургалт буюу цагдаагийн байгууллагад анх орж ажиллах ахлагч бүрэлдэхүүний сургалтыг ХСИС-ийн Ахлагчийн сургуульд 3 сарын хугацаатай зохион байгуулж байна.

Дээрх сургалтад хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалтыг ЦЕГ-ын хүний нөөцийн хэлтсээс зохион байгуулж, төгсөгчдийг цагдаагийн байгууллагын хүний нөөцөд бүртгэн томилж байна.

2012-2017 оны хичээлийн жилүүдэд ХСИС-ийн Ахлагчийн сургуулийг төгссөн иргэдийн тоон судалгааг харуулбал дараах байдалтай байна.

2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	Нийт
211	238	316	340	406	1511

Түүнчлэн ЦЕГ-ын даргын 2014 оны 706 дугаар тушаалын дагуу Сургалтын нэгдсэн төвд/тухайн үеийн/¹ цагдаагийн мэргэжлийн дамжааг 3 сарын хугацаатай зохион байгуулж, 53 иргэнд цагдаагийн мэргэжлийн үнэмлэх олгожээ.

2. Бакалаврын сургалт

Цагдаагийн байгууллагын офицер бүрэлдэхүүний хүний нөөцийн гол эх сурвалж нь ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн төгсөгчид бөгөөд тэднийг Хууль зүйн сайдын 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн мэргэшсэн алба хаагч бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн дагуу өдөр 2.5+(2)+1.5 жил ба 1+(1)+1 жил, эчнээ 3 жил /их, дээд сургууль төгссөн элсэгчид/ болон 5 жил /бүрэн дунд боловсролтой элсэгчид/-ийн хөтөлбөрөөр бэлтгэж байна.

2017-2018 оны хичээлийн жилд ХСИС-ийн цагдаагийн бакалаврын түвшний сургалтад нийт 1169 сонсогч суралцаж байгаагаас өдрийн ангид 31, эчнээ ангид 39 эмэгтэй сонсогч байна.

Хөтөлбөрийн нэр	Суралцагчдын тоо					
	I дамжаа	II дамжаа	III дамжаа	IV дамжаа	V дамжаа	Нийт
Цагдаа-хууль сахиулах ажил /өдөр/	151	179	188	173		691
Цагдаа-хууль сахиулах ажил /эчнээ 3 жил/	88	75	38			201
Цагдаа-хууль сахиулах ажил /эчнээ 5 жил/	30	69	64	50	64	277
Нийт	269	323	290	223	64	1169

¹ Цагдаагийн Ерөнхий газрын цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв

3. Магистр, доктор болон удирдлагын сургалт

2017 оны байдлаар цагдаагийн алба хаагчдыг ОХУ-ын зарим сургуулиуд, Монгол Улсын ХСИС болон бусад сургуульд магистр, доктор, удирдлагын түвшний сургалтад хамруулан бэлтгэж байна.

ХСИС-ийн магистрантурын сургалтад 2013 оноос хойш нийт 176 цагдаагийн албан хаагч элсэн суралцсанаас 84 нь магистрын зэрэг хамгаалж, үлдсэн алба хаагчдын сургалт үргэлжилж байна.

Харин тус сургуулийн докторантурын сургалтад 2013 оноос хойш нийт 30 цагдаагийн албан хаагч элсэн суралцсанаас одоогоор аль нь ч докторын зэрэг хамгаалаагүй байна. Эдгээр мэдээллийг сүүлийн 5 жилийн байдлаар дэлгэрэнгүй үзүүлбэл:

Хөтөлбөрийн н нэр	ХСИС-ийн магистр, докторын сургалтад хамрагдсан цагдаагийн албан хаагчдын тоон судалгаа											
	2013		2014		2015		2016		2017		Нийт	
	Элсэн	Төгссөн	Элсэн	Төгссөн	Элсэн	Төгссөн	Элсэн	Төгссөн	Элсэн	Төгссөн	Элсэн	Төгссөн
Магистр	33		18		32	30	65	25	28	29	176	84
Доктор	7				16		7				30	0

Хууль сахиулахын Удирдлагын академийн цагдаагийн стратеги-тактик удирдлагын мэргэжлийн болон хууль сахиулах удирдлагын магистрын хос диплом олгох сургалтанд 2013-2017 онд 27, цагдаагийн стратеги-тактик удирдлагын мэргэжлийн гарагын сургалтанд 1 цагдаагийн албан хаагч байгууллагын захиалгаар элсэн суралцсанаас 22 алба хаагч төгсөж, 5 алба хаагч суралцаж байна.

4. Давтан, мэргэжлүүлэх болон үр чадварын сургалт

Цагдаагийн алба хаагчийн давтан, мэргэжлүүлэх, үр чадварын сургалтыг тухайн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулж байна. ЦЕГ-ын даргын 2018 оны Б/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг үр чадварыг дээшлүүлэх 2018 оны сургалтын календарьчилсан төлөвлөгөө”-нд нийт 8 чиглэлийн 88 сургалт төлөвлөгдсөн байна.

Түүнчлэн олон нийтийн цагдаа бэлтгэх сургалт, иргэдэд зориулсан галт зэвсгийн сургалт, офицерийн дамжаа, албаны нохойн сургалтыг төлөвлөгөөний дагуу, бусад төрийн байгууллага, харьяа нэгжүүдээс ирүүлсэн захиалгын дагуу төлөвлөгөөт бус сургалтуудыг зохион байгуулдаг.

Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7-д заасны дагуу ёс зүйн төлбөртэй /51000 төгрөг/ сургалтыг 2016 оноос зохион байгуулж эхэлсэн бөгөөд одоогоор 2 удаагийн сургалтад нийслэлийн дүүргийн цагдаагийн хэлтсийн 44 ахлагч, 54 офицер алба хаагч хамрагдаад байна.

5. Нэгжийн сургалт

"Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх /Код 118/ журам"-ын 118.9.7-д заасны дагуу цагдаагийн байгууллага нь цагдаагийн төв байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэл, алба хаагчдынхаа сургалтын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн ажлын байранд зохион байгуулана.¹

SWOT шинжилгээ:

Давуу тал	Сул тал
1. Цагдаагийн алба хаагчдын сургалтын хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн, ур чадварыг нэмэгдүүлэх, дадлагад тулгуурласан зохиолмол орчин бүрдүүлсэн байна. 2. Цагдаагийн төв болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу албаны сургалтыг жил бүр зохион байгуулдаг. 3. Сургалт явуулах ажлын дадлага туршлага, мэргэшдийн мэдлэгтэй нийт 153 алба хаагч сургагч багшаар ажиллаж байна. 4. Алба хаагчийн сурч боловсроход дэмжлэг үзүүлэх, ажил үүгийн зохицуулалт хийж, тусалж дэмжих талаар удирдлагагаас багагүй анхаарч байна. 5. Эрх зүйн орчин хангалттай	1. Шинээр байгуулагдсан, өөрчлөгдсөн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, удирдлага зохион байгуулалтын ажлыг нь тогтоож өгсөн эрх зүйн баримт бичигтгүй байгаа нь хийдэл гарах нөхцөл бүрдүүлж байна. 2. Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалттай холбогдох харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг нэг мөр хэрэгжүүлэх талаар зарим цагдаагийн удирдлагууд харилцан адилгүй байгаа нь хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна. 3. Орон нутагт сургалтын хэрэгцээнд зориулсан төсөв бага хүрэлцдэггүй, компьютер техник хэрэгсэл дутагдалтай 4. Байгууллага бүрт сургагч багш байхгүй тул зохион байгуулагдаж байгаа сургалт технологийн дагуу явагдаж байгаа эсэх нь эргэлзээтэй
Боломж	Аюул ба Эрсдэл
1. Бусад сургалтын байгууллагатай харьцуулахад алба хаагчийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг мэргэшсэн алба хаагчдаар явуулах боломж	1. Алба хаагчдын цалин хангамж амьдрал ахуйд нь хүрэлцдэггүй тул өөрийгөө хөгжүүлэх, сургалтын зардалд зарцуулах мөнгө гаргах боломж бага

¹ Цагдаагийн байгууллагын албаны сургалтын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ, шинжилгээ., УБ.,2017он.

өндөр 2. Цагдаагийн дадлага сургалтын төв нь өнөөгийн байдлаар Монгол улсын хэмжээнд цагдаагийн дадлага, сургалтыг зохион байгуулах орчиныг бий болгосон 3. Цагдаагийн алба хаагчдын сургалтыг технологийн дагуу зохион байгуулах, сургагч багш нарыг заах арга зүй, сургалтын технологи эзэмшүүлэх чиглэлээр хамтарсан сургалтыг явуулах боломжтой	2. Олон улсын ихэнхи байгууллага болон төрийн бус байгууллагаас цагдаагийн алба хаагчдыг хөгжүүлэх төсөв, зарцуулах сонирхол бага 3. Зарим цагдаагийн удирдлагууд алба хаагчдыг сургах нөхцөл бололцоогоор хангахгүй эрх зүйн бусад их дээд сургууль төгссөн алба хаагчдыг авч ажиллуулах сонирхол бий болж байгаа нь бловсон хүчний чадавхи алдагдах эрсдэлтэй
--	---

Гурав. Сургалтын үнэлгээ

Байгууллагын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ бол хамгийн чухал, зайлшгүй үйл ажиллагаа юм. Хэрвээ сургалтын эцсийн үр дүнгийн үнэлгээ байхгүй бол сургалтын хөтөлбөрийн зорилго хэрхэн биелэгдсэн болохыг үнэлэх боломжгүй юм.

Сургалтыг үнэлэхдээ суралцагчдын тухайн сургалтанд хандах байдал, суралцаж олж авсан мэдлэг ба чадварын түвшин, зан үйл эсвэл гүйцэтгэлийн өөрчлөлт зэргийг судалж дүгнэнэ.

Цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагын захиалгаар мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, боловсрол эзэмших урт хугацааны сургалтад хамрагдах бол цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэстэй сургалтын гэрээ байгуулж, дүгнүүлэх ба байгууллагын захиалгаар сургалтын гэрээ байгуулан суралцаж байгаа алба хаагчийн гэрээний үүргийн биелэлтийг талууд жил бүр үнэлж, дүгнэнэ.

Цагдаагийн дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв болон бүсийн сургалтын төвд зохион байгуулагдсан сургалтын үр дүнг Цагдаагийн дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв нь өөрөө үнэлж, дүгнэхээс гадна сургалтын үйл ажиллагааны болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хөндлөнгийн үнэлгээ шинжилгээг боловсролын шинжилгээ үнэлгээний байгууллагаар хийлгэж болно.

Цагдаагийн төв байгууллагын харьяа нэгж болон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас ажлын байранд зохион байгуулсан сургалтын явц, үр дүнг Монгол Улсын Засгийн газраас тогтоосон ажлын үр дүнд үнэлгээ хийх журмын дагуу цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс дээрх үзүүлэлтийн агуулга нэг бүрээр улирал бүр шинжилгээ хийж, байгууллага бүрд оноо өгч байр эзлүүлэх бөгөөд тухайн жилд алба хаагчаас нь мэргэжлийн ба сахилга, ёс зүйн ноцтой алдаа гаргаж арга хэмжээ авагдсан болон нийтийн

хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн тохиолдлыг алба хаагчдын сургалт, хөгжлийн ажлыг дүгнэхдээ харгалзах үзүүлэлт болгон авч үзэг байна.

Дүгнэлт

Өөрчлөлт шинэчлэлтийн өнөөгийн үед сургалтын ач холбогдол өсч байгаа бөгөөд төрийн тусгай албадын нэг болох цагдаагийн алба нь өөрийн бие бүрэлдэхүүнээ мэргэшсэн, чадварлаг алба хаагчдаар бүрдүүлэх явдал юм.

Иймд цагдаагийн алба хаагчийн сургалтыг мэргэшүүлэх сургалтанд хамруулахдаа албан ажлаас түр хугацаагаар бүрэн чөлөөлж, гэрээний үндсэн дээр сургалтын чанар, үр дүнг дүгнэх, суралцагчийн хариуцлагын талаар гэрээнд тодорхой тусгаж дүгнэх, ажлын байран дахь сургалтыг мэргэшсэн сургагч багшаар Хууль сахиулах их сургуулийн цагдаагийн сургуультай хамтран онол, практикийн хосолсон түвшинд зохион байгуулах шаардлага байгаа нь харагдаж байна.

Мөн цагдаагийн байгууллагын албаны сургалтын бодлогыг тодорхойлж, удирдлага зохион байгуулалтаар хангах мэргэжлийн албатай болсон нь давуу талтай байна гэж дүгнэж байна.

Санал

Хурдтай хувьсан өөрчлөгдөх нийгэмтэй хөл нийлүүлэн, хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай биелүүлэхийн тулд аливаа байгууллага тасралтгүй хөгжиж суралцах хэрэгцээ шаардлагатай билээ. Энэ хөгжлийг чиглүүлэн манлайлах хүний нөөцийг бэлтгэх, шинэ шинэ боломжуудыг бий болгох нь тухайн байгууллагын хүний нөөц, сургалт, гадаад харилцаа хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагаанаас шууд хамаарч байдаг.

Иймд цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр дараах саналуудыг танилцуулж байна. Үүнд:

1. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх, сургалтыг зохион байгуулах, хяналт тавих, сургалтын үр дүнд судалгаа хийдэг арга зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах.

2. Мэргэшүүлэх сургалт явуулах сургагч алба хаагчдад багшлах ур чадвар, алба хаагчдыг сурган заах арга зүйн чиглэлээр мэргэшил олгох зорилгоор гадаад, дотоодын их дээд сургуульд суралцуулж бэлтгэх зэрэг болно.